



**ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

**Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт
оруулахыг дэмжих тухай**


Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэхь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 84 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 2.6 дахь хэсэг, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.16 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 1.4 дэхь хэсэгт заасан “...компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийн 66 хувийг Эрчим хүчний яам, 34 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус хэрэгжүүлнэ” гэснийг “...компанийн нийт хувьцааны 66 хувийн төлөөллийг “Эрчист Монгол” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, 34 хувийн төлөөллийг Эрчим хүчний яам тус тус хэрэгжүүлнэ” гэж өөрчлөлт оруулахыг дэмжсүгэй.

2. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан шийдвэрлүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /И.Лувсанцэрэн/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Л.Эрхбаатар/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



И.ЛУВСАНЦЭРЭН

1701040045